



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/324

Чингис хот

Мэдээллийн ил тод байдлыг хангахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.8, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангахад 1.950.000 /нэг сая есөн зуун тавин мянга/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн байгалийн гамшиг, түймрийн хохирлоос урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА